| | өөрчлөлтөд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах | *(Газрын Кадастр, үнэлгээ, төлбөр, татвар, бирж, хаяг, Газрын нэгдмэл сангийн систем)* | | | газрын даамлуудад өдөр тутам мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Газрын кадастрын мэдээллийн системд үүссэн өдөрт дунджаар 40-50, сард 800, жилийн эцсийн байдлаар 5750 орчим мэргэжилтэнтэй холбогдон системд оруулсан бүртгэлийн алдааг засварлаж, Газрын кадастрын мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.<br>Мөн Газрын кадастрын мэдээллийн системд иргэний гэр бүлийн хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших үйл ажиллагааг цахим системээр зохион байгуулах, эрх бүхий этгээдийн шийдвэр гаргуулах, Улсын бүртгэлийн Э, А дугаар авах, засвар хяналтын модулийг нэвтрүүлэх, ГКМС-д байршил зөрүүтэй бүртгэгдсэн нэгж талбаруудыг засварлах, нэгж талбарыг нөхөн бүртгэх зэрэг шинэчлэлт, хөгжүүлэлтийн талаар чиглэлүүдийг албан бичгээр хүргүүлж, 25 удаагийн сургалт мэдээллийг танхимаар болон цахимаар зохион байгуулж ажилласан. | | |
| 13. | Арга хэмжээ 3.7. Улсын бүртгэлийн ерөнхий газартай дундын мэдээллийн санг байгуулж, Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх | 3 системийг холбосон дундын мэдээллийн сан-1 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн. | Үндэсний ДАТА төвийн ХУР системд дундын мэдээллийн санг байгуулах системийн хөгжүүлэлтийн ажлыг эцэслэн дуусгаж хаягийн мэдээллийн системд бүртгэгдсэн өгөгдөл мэдээллийг сервис байдлаар | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нарын 2023 оны А/82, А/985 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан “Хаягийн болон газар, үл хөдлөх хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах” ажлын хэсгийн хүрээнд нийт 4 удаагийн уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн санг байгуулах ажлыг эрчимжүүлж газар өмчлөгчийн анхны болон эцсийн өмчлөгчийн мэдээллийг ГКМС-д холбох ажлыг “Софт мастер” ХХК-аар гүйцэтгүүлж, УБЕГ-тай дундын мэдээллийн сангийн анхны хувилбарыг туршиж байгууллага | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байршуулсан байна. | хоорондын мэдээлэл дамжих виртуал сервисийг үүсгэсэн. Мөн газар өмчлөгчийн түүхчилсэн мэдээллийг сервис байдлаар холбох ажлыг гүйцэтгэж, ГКМС-ийн өмчлөлийн бүртгэлд “ТҮҮХ” гэсэн талбарыг шинээр хөгжүүлсэн. Энэ хэсэгт улсын хэмжээний 711 мянган газар өмчлөгчийн мэдээллийн анхны өмчлөгч болон эцсийн өмчлөгчийн мэдээллийг холбоход бэлэн болсон бөгөөд эхний удаад Нийслэлийн хэмжээний 210 мянган газар өмчлөлийн мэдээллийг холбож хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>- Дээрх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нарын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/275, А/152 дугаар хамтарсан тушаалаар шинэчилж байгуулсан. Ажлын хэсгээс нийт 3 удаагийн уулзалтыг зохион байгуулж, дундын мэдээллийн санг улсын хэмжээнд нэвтрүүлэх, холбогдох арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. | | |
| **Зорилт 4. “Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах”** | | | | | | | |
| 14. | Арга хэмжээ 4.1. Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг аймаг, нийслэлээс хүлээн авч нэгтгэх, улсын нэгдсэн тайланг гарган Засгийн газарт танилцуулах, Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн товхимлыг | Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан, товхимол | Газрын нэгдмэл сангийн 2022 оны улсын нэгдсэн тайлан хэвлэгдсэн. | Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд танилцуулагдсан байна.<br>Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн | Газрын нэгдмэл сангийн тайланг аймаг, нийслэлээс хүлээн авах, нэгтгэн гаргах ажлын хэсгийг Газрын даргын 2024 оны А/01 тоот тушаалаар байгуулан тайлан хүлээн авах, нэгтгэх хуваарийг батлуулсан. Аймаг, нийслэлийн газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг ажлын хэсгийн гишүүд шалган хүлээн авч нэгтгэн гаргасан. Мөн улсын хэмжээний 2023 оны тайланг нэгтгэн 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд хурлаас | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэвлүүлэх, тайланг хэрэглэгчдэд хүргэх | | | тайлангийн товхимол хэвлэгдэн хэрэглэгчдийн хүртээл болсон байна. | гаргасан шийдвэрийн дагуу Монгол улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 14 дүгээр хуралдаанд танилцуулсан.<br>21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-нд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэлийг 2024 оны 1/1076 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг хэвлэх гүйцэтгэгчтэй 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 2024/126 дугаар гэрээ байгуулан, гэрээний дагуу 500 ширхэг тайланг хүлээн авсан.<br>Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг ЭХЯ, ЦХХХЯ, ХХААХҮЯ, АҮЭБЯ, ХЗҮХ, УЦУОСМХүрээлэн, УБЕГ, Хот байгуулалт, хотын стандартын газар, Үндэсний статистикийн хороо зэрэг нийт 26 аж ахуйн нэгж, байгууллагад тус тус албан бичгээр хүргүүлсэн. | | |
| **Зорилт 5. “Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх”** | | | | | | | |
| 15. | Арга хэмжээ 5.1. Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | • Газрын тухай хууль болон бусад журам, зааварт өөрчлөлт орсонтой холбогдуулан Газрын удирдлагын нэгдсэн цахим систем (Egazar.gov.mn)-ээр дамжуулан “Гэр бүлийн хамтын хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлт”-ийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх системийн хөгжүүлэлтийг эцэслэж, 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус ажлын хүрээнд 30,171 иргэний хүсэлтийг хүлээн авч, 3642 нэгж талбарыг санал болгон ажиллаж байна.<br>• Гэр бүлийн хамтын хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлтийг “Төрийн үйлчилгээний нэгдсэн цахим | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | систем И-Монголиа" системд холбож, 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>• Аймаг, нийслэлийн Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг хүлээн авах ажлын хүрээнд 21 аймгийн ГХБХБГ-ын албан хаагчид болон сумдын даамлуудад чиглэл өгч ажилласан бөгөөд нэгдмэл сангийн тайланг хүлээн авч, ДДЗХ-аар хэлэлцүүлэн ЗГ-т танилцуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан.<br>• Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан Ажлын хэсэгт Өмнөговь аймгийн Ханбогд сумын газар олголтын нөхцөл байдлын талаар судалгааг гаргаж тайлагнасан.<br>• УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан газрын сонсгол хийхтэй холбоотой улсын хэмжээний 2003-2023 оны хооронд Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн иргэн хуулийн этгээдэд олгосон газрын нарийвчилсан судалгааг хэлтсийн бусад мэргэжилтнүүдтэй хамтран гаргаж ажилласан.<br>• ЗГ-ийн 2020 оны 110 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, ГНС-ийн удирдлагын нэгдсэн цахим системийг сайжруулахтай холбоотой арга хэмжээг зохион байгуулж ЗГХЭГ-ийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийн хэрэгжилтийг хангаж Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газартай хамтран ажиллаж ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.<br>• Стрийм төсөлтэй хамтран Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт албан хаагчдад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын кадастрын мэдээллийн систем болон газрын нэгдмэл сангийн тайлан гаргахтай холбоотой танхимын сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулсан.<br>• Орон нутгийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах ажлын хүрээнд 21 аймгийн ГХБХБГ-ын кадастрын асуудал хариуцсан албан хаагчдад 2024 оны 05 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд танхимын сургалт зохион байгуулсан.<br>• Монгол Улсын Ерөнхийлөгчийн өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд газрын хяналт шалгалтын ажлын үр дүнгийн танилцуулга бэлтгэж, ажлын хэсгийн хурлыг 2024 оны 05 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>• Байгууллагын цахим хуудасны шинэчилсэн хувилбарт ГКМС болон хаяг, Газрын нэгдмэл сангийн цахим систем, Хот байгуулалтын системүүдийн танилцуулгыг байршуулсан бөгөөд egazar.gov.mn системээс авах 23 төрлийн үйлчилгээг хэрхэн авах талаар зааварчилгааг бэлтгэж оруулсан.<br>• Гэр бүлийн хамтын хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлтийн нарийвчилсан судалгааг гаргасан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоолын дагуу “Гэр бүлийн хамтын хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших” хүсэлтээ цахимаар ирүүлсэн нийт 40,475 хүсэлтийг хүлээн авч, сонгогдсон газраа баталгаажуулсан 3,505 иргэн байгаа бөгөөд үүнээс 862 нэгж талбар засаг даргын захирамж гарч шийдвэрлэгдсэн байгаа талаар нэгжийн удирдлагад танилцуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Гэр бүлийн хамтын хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлт гаргаж санал болгосон газраа баталгаажуулсан 3,505 иргэний Засаг даргын захирамж шийдвэр гаргуулах, гэрчилгээ олгох ажлыг эрчимжүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байгаа талаар 21 аймгийн ГХБХБГазрын албан хаагчидтай 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр цахим хурлыг зохион байгуулсан.<br>• Гэр бүлийн хамтын хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлт гаргаж санал болгосон газраа баталгаажуулсан 3,505 иргэний Засаг даргын захирамж шийдвэр гаргуулах, гэрчилгээ олгох ажлыг эрчимжүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байгаа талаар 21 аймгийн ГХБХБГазрын албан хаагчидтай 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр цахим хурлыг зохион байгуулсан.<br>• Гэр бүлийн хамтын хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших 41,322 цахим хүсэлт Улсын хэмжээнд хүлээн авсан бөгөөд үүнээс 792 хүсэлтийг аймаг, сумын засаг дарга шийдвэрлэсэн байна. Шийдвэрлээгүй хүсэлтүүдийг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх талаар 21 аймгийн ГХБХБГ-т чиглэл хүргүүлсэн болно.<br>• Байгууллагын цахим хуудасны шинэчилсэн хувилбарт Газрын кадастрын мэдээллийн системийн танилцуулгыг байршуулсан бөгөөд Egazar.gov.mn системээс авах 23 төрлийн үйлчилгээг хэрхэн авах талаар зааварчилгааг бэлтгэж оруулсан.<br>• Газар эзэмших, ашиглах эрхийг Улсын бүртгэлд бүртгэх мэдүүлгийг цахимжуулах үүргийн хүрээнд Улсын бүртгэлийн мэдүүлгийн загварыг өөрчилж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэний гарын үсгийг нууцлал бүхий QR кодтойгоор үүсгэх талаар Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллахаар тохиролцсон. Үүний дагуу 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлж, иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардагддаг 4 төрлийн хавсралт материалыг цахим системээс автоматаар QR кодтойгоор үүсгэж, дундын мэдээллийн сангаар дамжуулан, "Э", "А" дугаарыг авдаг болсон. Ингэснээр иргэн, хуулийн этгээд нь газрын албанд биеэр очих шаардлагагүйгээр хүсэлтээ цахимаар гарган, цахим систем нь албан хаагчийн оролцоогүйгээр холбогдох баримт бичгүүдийг үнэн зөв, хурдан найдвартай улсын бүртгэл рүү илгээж, шат дамжлагыг 70 хувиар, мэргэжилтэнд ирдэг ачааллыг 50 хувиар бууруулсан.<br>• Гэр бүлийн хамтын хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлт ирүүлсэн иргэдийн судалгааг нарийвчлан шийдвэрлэгдээгүй 2643 хүсэлтийг иргэн тус бүрээр гаргаж, тухай асуудлыг яаралтай шийдвэрлэх талаар орон нутгуудад чиглэл хүргүүлж хамтран ажиллах тухай 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1/2425 дугаартай албан бичгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.<br>• Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн цахим систем /веб/-ийн зохиогчийн эрх авахад шаардлагатай материалуудыг бүрдүүлэн байгууллагын Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газарт хүргүүлсэн.<br>• Евразийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар бүс нутгийн хуралдааны үеэр Газрын нэгдмэл сангийн удирдлагын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгдсэн цахим систем (Egazar.gov.mn)-ийн талаар хуралдаанд оролцогчдод танилцуулсан.<br>• Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн систем дээр засварлах шаардлагатай 2512 нэгж талбарыг идэвхигүй төлөвт шилжүүлж ажилласан.<br>• Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлтэй Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын эзэмшлийн газруудын судалгааг гаргаж Санхүү, эдийн засгийн хэлтэст хүргүүлсэн. | | |
| 16. | Арга хэмжээ 5.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | • Газрын даргын 2024 оны А/01 дугаар тушаалаар байгуулсан аймаг, нийслэлийн Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг хүлээн авч, нэгтгэн нэгдсэн тайлан гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан.<br>• Газрын даргын 2024 оны А/02 тушаалаар байгуулагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан.<br>• Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу “Монгол улсын Засгийн газар хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хяналт тавих чиг үүргийн хүрээнд Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгуулагдсан иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан асуудлыг шалгаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан.<br>• Газрын даргын 2024 оны А/272 дугаар тушаалаар байгуулсан Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн Газрын кадастрын | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийн системд бүртгэгдсэн цахим хувийн хэргийн бүрдүүлэлт болон эрх бүхий этгээдийн шийдвэрийн бүртгэл, нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийн арга хэмжээнд хяналт хийж, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан.<br>• Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нарын хамтран баталсан 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/275, А/152 дугаартай "Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан"-г байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. | | |
| 17. | Арга хэмжээ 5.3. Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | • ЗГ-ын 2024 оны 58 дугаар тогтоолын хоёрдугаар заалтын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн өргөн царигийн төмөр замын шугам, Монгол Улсын хилийн Гашуунсухайт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод Боомтыг холбох хил дамнасан нарийн царигийн төмөр замын шугамын чигтэй давхацсан газрыг чөлөөлөх, шинээр газар олгохгүй байх нөхцөлийг бүрдүүлж, ГКМС-ийн нууцын давхаргад бүртгэж хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>• Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан Ажлын хэсгийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийн дагуу улсын хэмжээнд хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх биелэлтийг тухай бүр гаргаж ажилласан.<br>• ЗГ-ын 2023 оны 234 дүгээр тогтоолын нэгдүгээр заалтын дагуу Тусгай хэрэгцээний газар, нийтийн эдэлбэрийн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газар, зам, шугам сүлжээний газар, ойн болон усны сан бүхий газар, тэдгээрийн хамгаалалтын бүс газарт хууль тогтоомж зөрчин газар эзэмшиж, ашиглаж байгаа, барилга байгууламжийн судалгааг гаргасан.<br>• ЗГ-ын 2023 оны 13 дугаар тэмдэглэлийн 4.3 дах заалтын дагуу төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшлийн болон нийтийн эдэлбэр газрыг бусдад эзэмшүүлсэн, зориулалтыг өөрчилсөн, барилга байгууламж барьсан талаарх судалгааг 1996 оноос гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.<br>• Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хэрэгжилтийн талаар КХ-ээс хамааралтай 4 заалтын хэрэгжилтийг нэгтгэж, ахлах мэргэжилтэнд хүргүүлсэн. | | |
| 18. | Арга хэмжээ 5.4. Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр хийгддэг. | Ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Тайлант хугацаанд нийт 139 албан бичиг хуваарилагдан ирснээс хариутай 88, хариугүй 51 албан бичиг байна. Хариутай 88 албан бичгийг 87-г нь шийдвэрлэсэн, 1 албан бичиг хяналтын шатанд байна. Мөн иргэнээс нийт 39 өргөдөл, хүсэлт ирснийг 100 хувь шийдвэрлэн хариу өгч ажилласан байна. | 01-12 | 100 |
| 19. | Арга хэмжээ 5.5. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | Урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | Тус ажлын хүрээнд 2024 оны III улирлын байдлаар иргэн хуулийн этгээдээс ирүүлж, шийдвэрлэсэн нийт 88 албан бичиг, 39 өргөдөл гомдлын цаасан материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу Салбарын архивын хэлтэст хүлээлгэн өгсөн. | 01-12 | 100 |

**Хоёр. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Нийслэл, дүргийн Газар зохион байгуулалтын албаны хүлээн авч шийдвэрлэсэн болон шийдвэрлээгүй хүлээгдэж буй өргөдлийн тоог гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Нийслэл, дүргийн Газар зохион байгуулалтын албаны 2023 онд хүлээн авч шийдвэрлэсэн болон шийдвэрлээгүй хүлээгдэж буй өргөдлийн тоог алба тус бүрээр гаргасан бөгөөд нийтдээ 17986 өргөдлийг шийдвэрлэсэн талаар тайланг гаргаж хэлтсийн даргад танилцуулсан. | 01-12 | 100 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Төв-Гандантэгчэнлин хийдийн орчмын газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах ажлын хүрээнд нэгж талбарын судалгаа гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Төв-Гандантэгчэнлин хийдийн газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах ажлын хүрээнд Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлтэй 836 өмчлөл, 258 эзэмшил, ашиглалтын нийт 1094 нэгж талбарын дэлгэрэнгүй судалгааг гаргаж Газар зохион байгуулалтын хэлтэст хүргүүлж ажилласан. | 01-12 | 100 |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Хөшигийн хөндийн нэгж талбарын судалгааг гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Хөшигийн хөндийн Улсын тусгай хэрэгцээнд авсан газрын хил заагт хамаарч буй 112 нэгж талбаруудын эрх шилжсэн, хугацаа сунгасан дэлгэрэнгүй судалгааг гаргаж Газар зохион байгуулалтын хэлтэст хүргүүлэн ажилласан. | 01-12 | 100 |

194

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Баруун бүсийн 5 аймгийн цахим хүсэлт хүлээн авах болон түүний шийдвэрлэлтийг гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Баруун бүсийн 5 аймгийн албан хаагчдыг чадавхижуулах сургалтын хүрээнд Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд, Завхан аймгуудын Газрын удирдлагын нэгдсэн цахим систем /Egazar.gov.mn/-р дамжуулан иргэн, хуулийн этгээдээс цахимаар хүлээн авсан хүсэлтийн нийт тоо, тэдгээрийн хянаж шийдвэрлэсэн байдлын тайланг гаргаж ажилласан. | 01-12 | 100 |
| 5. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Оюутолгой ГХОХХК-ийн ашиглаж буй нэгж талбарын судалгаа гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт Оюутолгой ГХОХХК-ийн ашиглаж буй 11 нэгж талбарын Газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээн судалгааг гаргаж хэлтсийн даргад тайлагнасан. | 01-12 | 100 |
| 6. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Хамгаалалтын бүстэй давхцалтай нэгж талбарын судалгааг гаргаж БХБЯ-нд хүргүүлэх | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | БХБЯ-аас ирүүлсэн 47 барилга, байгууламжийн мэдээллийг Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлтэй Хамгаалалтын бүсийн мэдээлэлтэй давхцуулан шалгасан. Нийт 12 хамгаалалтын бүстэй давхцалтай талаар зураг, хүснэгт бэлтгэж БХБЯ-нд хүргүүлсэн. | 01-12 | 100 |
| 7. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. Улаанбаатар хотын Бага тойруу орчмын газар ашиглалтын судалгаа гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Улаанбаатар хотын Бага тойруу орчмын 84,98 га талбайн 232 нэгж талбарын газар ашиглалтын судалгааг гаргасан. Тухайн нэгж талбаруудын газар эзэмшигч, ашиглагчийн төрөл буюу Монгол Улсын хуулийн этгээд, Монгол Улсын төрийн байгууллага, Гадаадын хуулийн этгээд, Монгол Улсын иргэн, Сууц өмчлөгчдийн | 01-12 | 100 |

195

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбоогоор нь ангилан, нэгж талбар бүрт хамаарах хүний тоог тооцож гаргасан. | | |
| 8. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. Өмнөговь аймгийн Ханбогд сум болон Цагаанхад орчмын газар олголтын судалгаа гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Өмнөговь аймгийн Ханбогд сумын өмчлөлийн 4419, эзэмшлийн 1750, ашиглалтын 36 нийт 6205 нэгж талбарын газар олголтын судалгааг гаргаж зургийг бэлтгэн хэлтсийн даргад тайлагнасан. | 01-12 | 100 |
| 9. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. Байгалийн нөөц газар, Байгалийн дурсгалт газрын ангилалаар авахаар санал болгож буй байршлуудын судалгааг гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Дорнод, Сүхбаатар, Ховд, Говь-Алтай, Дорноговь, Хэнтий, Өвөрхангай, Баянхонгор, Увс аймгуудын Байгалийн нөөц газар, Байгалийн дурсгалт газрын ангилалд шилжүүлэхээр санал болгож буй 19 байршилтай давхцаж буй 24122.6 га талбайтай 926 нэгж талбарын дэлгэрэнгүй судалгаа болон зурган мэдээллийг бэлтгэж хэлтсийн даргад тайлагнасан. | 01-12 | 100 |
| 10. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу судалгаа гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хүрээнд Ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхцалтай өмчлөлийн мэдээлэл болон Соёлын өвийн мэдээллийн судалгааг гаргаж Геодези, зурагзүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэгт хүргүүлсэн. | 01-12 | 100 |
| 11. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 11. Газрын кадастрын мэдээллийн | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг | Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн цахим систем дэх “Зөвшилцсөн зураг төсөл” | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгдсэн цахим систем дэх “Зөвшилцсөн зураг төсөл” давхаргыг шинэчилж бүтцийг өөрчлөн, давхцал шалгах | | | тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | давхаргыг хүснэгтэн мэдээллийг шинээр зохион байгуулж тухайн давхартай давхцуулж газар олгох боломжгүй байдлаар хориглох системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. | | |
| 12. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 12. Туул хурдны замын талбайн мэдээллийг Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэх | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 307 дугаар тогтоолоор батлагдсан “Туул голын хурдны зам”-ын талбайн солбицлыг Газрын кадастрын мэдээллийн системийн “Хориглолтын давхарга”-д бүртгэсэн. Мөн тухайн талбайд давхцаж буй иргэн, хуулийн этгээдэд өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулсан нэгж талбарын судалгааг гаргаж нэгжийн даргад танилцуулсан. | 01-12 | 100 |
| 13. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 13. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын нэгж талбарын судалгааг гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын нутаг дэвсгэрт эрх бүхий этгээдийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд олгогдож Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн нэгж талбарын судалгааг гаргаж байгууллагын удирдлагад хүргүүлсэн. | 01-12 | 100 |
| 14. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 14. Малчдын шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд судалгаа гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Малчдын шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 21 аймгийн хэмжээнд эрх бүхий этгээдийн шийдвэрээр хоршоонд олгосон 114 нэгж талбарын 488,96 га талбайн судалгааг нарийвчлан гаргаж Газар зохион байгуулалтын хэлтэст хүргүүлсэн. | 01-12 | 100 |

197

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 15. Богдхан уулын Улсын тусгай хамгаалалттай газар нутагт олгосон газрын судалгаа гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Богдхан уулын Улсын тусгай хамгаалалттай газар нутагт эрх бүхий этгээдийн шийдвэрээр олгосон газрын судалгааг эрхийн төрөл тус бүрээр нь гаргасан бөгөөд эзэмшиж буй 537, өмчилж буй 142, ашиглаж буй 1978 нэгж талбар бүхий 2529,02 га талбайн мэдээллийг нарийвчлан гаргаж Газар зохион байгуулалтын хэлтэст хүргүүлсэн. | 01-12 | 100 |
| 16. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 16. Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлтэй "Улсын хилийн зурвас газар"-ын мэдээллийг засварлах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлтэй "Улсын хилийн зурвас газар"-ын мэдээллийг засварлах ажлын хүрээнд Газар зохион байгуулалтын хэлтсээс батлагдсан мэдээллийг хүлээн авч засварлан ажилласан. | 01-12 | 100 |
| 17. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 17. Засгийн газрын тогтоолын дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх Төр захиргааны байгууллагын байр барих зориулалтаар Улсын тусгай хэрэгцээнд авсан газрын Гэрчилгээ, кадастрын зургийг гаргах | Үүрэг даалгаврын тоо | - | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хэрэгжүүлэх, тайлагнасан байна. | Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 132 дугаар тогтоолын дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэр дэх Засгийн газрын төр захиргааны төв байгууллагуудын нэгдсэн байр барих зориулалтаар 1000 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авсан бөгөөд тухайн газрын "Улсын тусгай хэрэгцээний газрын гэрчилгээ, Кадастрын зураг"-ийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 05.10-12.12 | 100 |
| 18. | Засгийн газрын батлагдсан тогтоолын дагуу иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх хүсэлтийг | - | Газрын кадастрын мэдээллийн систем | Цахимаар хүсэлт илгээдэг болсон байна | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 74, 131 дүгээр тогтоолуудаар тус тус батлагдсан улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын | 05.10-12.12 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | газрын удирдлагын нэгдсэн систем (egazar.gov.mn)-ээр дамжуулан цахимаар хүлээж авах ажлыг зохион байгуулах | | | байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтаас иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх 1495 нэгж талбарт цахим системээр дамжуулан хүсэлт авахад цахим системийн туршилт тохируулгын ажлыг гүйцэтгүүлэн, бэлтгэл ажлыг зохион байгуулж, аймгийн ГХБХБГ-т чиглэл хүргүүлж ажилласан. Цахим системээр дамжуулан 2024.11.13-ны өдрөөс 11.28-ны өдрийн хооронд 4016 хүсэлтийг хүлээн авч, эрэмбэлэн, иргэдэд санал болгосон газруудыг баталгаажуулах хүртэл үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. | | |

**Гурав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Өгөгдлийн сангийн бүтэц зохион байгуулалт, MySQL, PostgreSQL хэлний мэдлэгээ дээшлүүлж сургалтад хамрагдсан байна. | Сургалтад хамрагдах. | Анхан шатны мэдлэгтэй. | Цахим сургалтад хамрагдах, бие даан судлах | Программ хангамжийн цахим сургалтад хамрагдаж 5 модул хичээлийг судалсан. | 01-12 | Өгөгдлийн сангийн удирдлага, бүтэц зохион байгуулалт /PostgreSQL, MySQL/ сэдвээр 21 цагийн 90 видео хичээлүүдийг цахимаар суралцахаар бүртгүүлсэн бөгөөд 90 видео хичээлийг бүрэн үзэж, суралцан өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. |
| 2. | Арга хэмжээ 2. | Бие даан судалж анхан шатны | - | Бие даан судалсан байна. | Программ хангамжийн Phyton | 01-12 | Тус ажлын хүрээнд Python хэл болон программчлалын суурь мэдлэг, Машин сургалт сэдвээр |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Машин сургалт ба Phyton хэлний талаар бие даан суралцах | мэдлэгтэй болох | | | хэлний талаар бие даан судалж байна. | | 23 цагийн 90 видео хичээлийг цахимаар суралцахаар бүртгүүлсэн бөгөөд 90 видео хичээлийг бүрэн үзэж, суралцан өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Газрын кадастрын мэдээллийн сан хариуцсан, мэргэжилтэн
( Албан тушаал )

................................ /Ц.Ламзав /
( Нэр, гарын үсэг )

2024 - 12 - 05
( Огноо )